

ИХ ШАВИЙН БҮГДИЙН ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТУХАЙ ТОДРУУЛАХ НЬ (1911-1915)

Г. БАЯРМАА

Товч агуулга: 1911 онд Монголчууд төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхаглаж VIII Богд Жибзундамба хутагтыг Монгол улсын шашин төрийг хослон барьсан хаанд өргөмжилсөн билээ. Богд хааны анхны зарлигаар Их шавийн Эрдэнэ шанзудбын яамыг шинэ бүтэц зохион байгуулалтай болгон найман зүгийн бүгдийн дарга, дэд даргын албан тушаалыг бий болгосон байдаг авч тэрхүү бүгдийн даргыг гүйцэтгэх ажил, эрх мэдэл зэрэг асуудлыг авч үзсэн бүтээл хараахан гараагүй байна. Тиймээс энэ өгүүлэлд, Бүгдийн даргын алба хэрхэн байгуулагдсан хийгээд татан буугдсан, тамгын жасааны ажил үүрэг, эрх тушаал, бүгдийн дарга нарын нийгмийн статусын асуудлыг тодруулахыг зорив. Чингэхдээ Үндэсний Төв Архивт хадгалагдаж буй Их шавийн Эрдэнэ шанзудбагийн яам, Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яамны данс хараанд хадгалагдаж буй эх сурвалжуудыг ашиглалаа.

Түлхүүр үг: Жибзундамба, Эрдэнэ шанзудба, Бүгдийн дарга, бүтэц, үйл ажиллагаа, нийгмийн статус.

Оршил

Энэхүү өгүүлийг эхлүүлэхийн өмнө Эрдэнэ шанзудбын албан тушаал, яамын үйл ажиллагааг тодруулах нь зүй болов уу. 1639 оноос Жибзундамба хутагтын шавь нар бий болсон цагаас Жибзундамба хутагтын харъяа шавь нартай холбоотой асуудлыг Хамба номун хан, Эрдэнэ шанзудба нараар дамжуулан шийдвэрлэн зохицуулсаар ирсэн байна.

Хамба номун хан нь хутагтын шавийн хувраг, ном хурал, сургууль шашны асуудлыг эрхлэн шийддэг бол, Эрдэнэ шанзудба нь хар шавь нартай холбоотой асуудлыг эрхлэн шийдэхийн сацуу хувраг нартай холбоотой асуудлыг ч мөн шийдэж (гэмт хэрэг) байжээ.

Доктор З.Нинжбадгар Жибзундамба хутагтын шавь нарыг захирах Хамба номун хан, Эрдэнэ шанзудбын албан тушаал буй болсон явдлыг 1651-1709¹ оны үед хамруулж үзжээ. Тэрээр Манж Чин улсын Найралтөв хаан 1723 онд Хамба номун хан, Эрдэнэ шанзудбын тушаалыг хүлээн зөвшөөрч, сургах зарлиг тамга олгон баталгаажуулсан² хэмээн үзэж Эрдэнэ шанзудбын яам байгуулагдсан явдлыг тодруулсан судалгааны ажил хийсэн байна.

Жибзундамба хутагтын шавийн захиргаа болох Эрдэнэ шанзудбын яам нь

¹ Нинжбадгар З, *Жибзундамба хутагтын шавийн захиргаа* (ХҮП-XX зууны эхэн), УБ, 2014, 33.

² Мөн дээрх, 56.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

харъяат хутагтын шавийн бүх отог, Жибзундамба хутагтын сан, Их хүрээний аймаг, дацангууд, Баруун Хүрээ, Амарбаясгалант, Дамбадаржаа, Эрдэнэ зуу, Бэрээвэн, Манзушир зэрэг хүрээ хийдүүдийг харъяалан захирдаг байв. Эрдэнэ шанзудбын яамны эрхлэх ажил нь,

- Хутагтын Их сангийн хамаг хэрэг.
- Төвдээс тодорсон Жибзундамба хутагтын дүрүүдийг Халхад авчрах, ширээнд залахад оролцох.
- Хүрээний аймаг, дацангуудын албан тушаалтнуудын ажил үүрэгтэй холбоотой дүрэм журмыг боловсруулан хяналт тавьдаг. Жишээ нь, Яамны дүрэм гаргах, мөрдүүлэх.
- Сүм хийдүүдийн тэргүүлэх албан тушаалтанг томилох. (Хамба номун ханы хамт)
- Харъяа сүм хийдийг шинэчлэн засах, сэлбэх.
- Шавийн захиргаанд алба хаших дээд тушаалтнуудыг сонгох санал оруулах,
- Шүүн таслах
- Эрдэнэ шанзуба нар нь хутагтыг шавийн отгийн дарга нарыг томилж Жибзундамба хутагтад танилцуулах

гэх мэт олон ажлуудыг хариуцаж байв.

1911 онд Ар Монголчууд тусгаар тогтнолоо зарлан тунхаглаж, 5 яам бүхий Засгийн газрыг байгуулаад, дотоодын элдэв хэргийг шинэчлэх ажлууд хийсний нэг нь Их шавийн Эрдэнэ шанзудбын яаманд бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийсэн явдал юм. Энэхүү өөрчлөлтөөр Халхын дөрвөн аймгийн нутагт тархан суух Жибзундамба хутагтын шавь нарыг найман зүгт хуваан бүгдийн даргын тамгын газрыг байгуулжээ. Энэ тухайд VIII Богд Жибзундамба хутагт Монгол улсын хаан ширээнд залраад Хишиг тархааж буулгасан зарлигт,

“...Хүрээний найман зүгийн тус зүг дэх шавь нарыг захирах бүгдийн даргад нийгээд тус зүгийн бага дарга нараас сонгон тохоон тавьж, тамга олгон хэрэг шийтгүүлэн засгийн хууль ёсоор явуул. Өөр өөрийн нийгээд дарга тавьж, туслагчийн хууль ёсоор явуул. Ихээхэн хэргийг хуучин ёсоор Эрдэнэ шанзудба, Да лам нарын газраа мэдүүлэн тогтуул”³

хэмээжээ.

Өмнөх судалгаа буюу Г.Навааннамжил⁴, Л. Дэндэв⁵, Н. Магсаржав⁶, Д. Цэдэв⁷, О. Пүрэв⁸ нар Найман зүгийн бүгдийн даргын газрыг шинээр байгуулсан болохыг дурдсан авч гол анхаарлаа тухайн үеийн байдлыг, шашин төрийг хослон

³ Монгол улсын Үндэсний Төв Архив (МУУТА), ХА-3, Д-1, ХН-2, 83-115.

⁴ Навааннамжил Г, *Автономийн үеийн Гадаад монгол улсын түүх, Галсангийн Навааннамжилын бүтээлийн дээжис*, УБ, 2011, 128.

⁵ Дэндэв Л, *Монгол улсын товч түүх*, УБ, 2012, 171.

⁶ Магсаржав Н, *Монгол улсын шинэ түүх*, УБ, 2010, 24.

⁷ Цэдэв Д, *Их шавь*, УБ, 1964, 30.

⁸ Пүрэв О, *Монгол улсын түүхэн газар зүй*, УБ, 2009, 40.

барьсан хаантөр тогтсон учир шалтгаан, төрийн хэрэгтлам хуврагын дээдхэсгийнхэн хэрхэн оролцох болсон хийгээд тус оронд засаг захиргааны иргэний болон шашны хэмээх хоёрдмол засаглал тогтож байсан тухайд хандуулсан буй. Тиймээс энэхүү өгүүлэлд, Найман зүгийн бүгдийн даргын тамгын жасаадыг авч үзэх ба чингэхдээ түүний үүсэн байгуулагдсан нөхцөл шалтгаан, эрх үүрэг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, татан буугдсан шалтгаан, бүгдын дарга нарын нийгмийн статусын байдал зэрэг асуудлыг хөндөнө.

1. Найман зүгийн бүгдийн даргын тамгын газрыг байгуулсан нь

VIII Богд Жибзундамба хутагт хааны шавь нарыг захирах Эрдэнэ шанзудбын яаманд зохион байгуулалтын өөрчлөлтийг хийхдээ харъяа найман зүгийн бүгдийн даргын тамгын газрыг Засгийн хууль ёсоор буюу хошуу тамгын статустай байгуулжээ. Эл үеийн Монголын шашныхны засаглал нилээд онцлог байсан байна. Монголын шашин, төрийн нэрт зүтгэлтэн Дилов хутагт Жамсранжав дуртгалдаа, Монголын бүх хүрээ хийд харьцангуй бие даасан байдалтайгаас гадна шашны болон засаг захиргааны хосломол шинжтэй бөгөөд санхүүгийн гол эх үүсвэр нь сүсэгтний өргөл барьц байсан⁹ гэж дурьдсанаас үзэхэд, сүсэгтэн олны өргөл барьцаас бүрдсэн эд хөрөнгөөр сан, жас байгуулдаг байсан байна. Сүм хийдийн шашин мөргөл, аж ахуйн үйл ажиллагаанаас гадна шавь нарыг захирах захиргааны ажлын уламжлал байсныг 1911 онд байгуулагдсан Олноо Өргөгдсөн Монгол улс эл чиглэлийн үйл ажиллагааг нь нэгтгэн зангидах шинэ механизмыг чухамдаа Их шавийн яаманд анх хэрэгжүүлжээ. Тиймээс ч энэхүү шинээр буй болгосон Бүгдийн даргын үйл ажиллагааг “Засгийн ёсоор явуул”¹⁰ хэмээн зарлиг буулгасан байна.

Богдгэгээний харъяат Их шавь 30 их отогтой¹¹гэх боловч их, бага хэмээн хуваасан 160 орчим отог, багт¹² хуваагдаж байжээ. Энэ нь хутагтын шавь нар анхнаасаа өөрийн тодорхой нутаг үгүй, Халхын дөрвөн аймгын нутагт таран нутаглаж байсантай холбоотой. Тиймээс тэднийг зүг бүрт нэгтгэн зангидваас, Их шавийн орон нутаг дахь хэрэг явдал нэлээд цэгцрэх мэт. Тиймээс ч зүг бүр дэх отог багуудыг захирах бүгдийн даргын газар байгуулах ажлыг Олноо Өргөгдсөний тэргүүн оны өвлийн сүүл сарын 14-нд (1912.2.2) Хүрээний Хэрэг

⁹ Дилов хутагт Жамсранжав, *Ар Монголын улс төрийн дуртгал*, УБ, 1991, 11.

¹⁰ Засаг нь тусгай нэг хошууг үе залгамжилж, захирсан тамгатай алтан ургийн тайж юм. Засаг ноёд хошуу захирах ажлыг туслагч түшмэдийн тусламжтай явуулдаг байсны нэг адил Бүгдийн даргын газрын үйл ажиллагааг хошуу засаг ноёны нэгэн адил явуул гэсэн зарлиг буулгажээ.

¹¹ *Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг хууль зүйлийн бичиг*, Тэргүүн дэвтэр, Бүгд хууль, Дээд хэсэгт Их шавийг 30 их отогтой хэмээгээд нэрсийг нь жагсаан бичжээ. *Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг*, УБ, 2010, 23.

¹² Хутагтын шавын отог, багуудыг Эрдэнэ шанзудбын газраа 3 жилд нэг удаа тоолон бүртгэдэг байсан ба 1912, 1915, 1918, 1921 оны тоогоор их отог 19, бага отогийн тоо 1915 онд 135, 1918 онд 143 байжээ. МУУТА. ХА-74, Д-1, ХН-507, 663 -их отогүүдын данс, ХА-74, Д-1, ХН-143, 508: бага отогүүдын данс.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

Шийтгэгч Шавь Бүгдийг Захирах Эрдэнэ шанзудба Бадамдорж, Шадар сайд бүгд захирах сайд Дотоод Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яам(хойшид ДХБЗШЯ хэмээн товчилно)-ны тэргүүн сайд Да лам Цэрэнчимэд, Да лам Дашжав, Гадаад хэргийг эрхлэн шийтгэх яамны Дэдсайд Да лам Равдан нар хэлэлцэн шийдвэрлэж¹³, ДХБЗШЯ—нд мэдүүлсэнд, тус яамнаас Богд хаанд айлтган баталгаажуулсан байна. Тэгэхдээ Дотоод яамнаас Эрдэнэ шанзудба Да лам нарт мэдүүлж,

“...харъяатхүрээний найман зүгийн тус зүг дэх шавь нарыг захирах бүгдийн дарга, дэд даргад тавиваас зохих хүн нарыг олон отгийн их, бага дарга нарын дотроос ... олны санааг дагуулж чадахийг зүг дутам өөр өөрийн хэд хэдийг сонгон томилож нэр зэргийг тодорхойлон бичиж биесийн хамтаар мэдүүлэн ирүүл”¹⁴

хэмээсний дагуу явуулжээ. Тухайлбал, Зүүн зүгийн отгийн дарга нараас Эх Дагины зайсан тайж дарга Намжилдэв, Хүүхэн хувилгааны дарга Цэрэн-Очир, Эрхийн хөөгч дарга Цэрэнпунцаг, Тойн ламын зайсан дарга Сэдэд¹⁵ гэх мэт зүг бүрээс дөрөв дөрвөн хүнийг томилон ирүүлсэнд зайсан Цэвээнням¹⁶ хүлээн авч ДХБЗШЯ-нд хүргэн ирсэн байна. ДХБЗШЯ-ны тэргүүн сайд да лам Цэрэнчимэдээс,

“...харъяат дарга нараас биесийг бие тулж магадлан үзвээс цөм хичээнгүй болгоомжтой тушаалд тэнцэх тул бүгдийн дарга, дэд даргад тогтоон тавихад тохох, таслахыг ялган салгаж 32 хүний нэрийг тусгай хуудас бичиж таслуулан хичээнгүйлэн нугалбар бичиж биесийг авч дээр үзүүлэн айлтгаад Богдгэгээнээ томилож эдгээр бүгдийн дарга тавих хүн нарыг цөм зарлиг заан тогтоохыг гуйхаас гадна Бүгдийн даргыг засаг хууль ёсоор явуул хэмээсний тул тэргүүн зэрэг жинс, Дэд даргыг туслагчийн хууль ёсоор явуул хэмээсэн тул дэд зэрэг жинс тус тус шагнан хадаглуулж үүрд дагаж явуулваас болох ба үл болох явдалыг хамтатган гаргаж хичээнгүйлэн айлтгав. Зарлиг гуймой хэмээн айлтгасанд, мөн өдөр хүлээн авсан уг нугалбарт Улаан бийрээр цохсон зарлиг байгуулсан¹⁷ ба бүгдийн даргад ... Намжилдэв, Лувсанцэрэн, Пунцаг, Сүндэв, Гомбо, Дондов, Доржпалам, Лувсандорж. Дэд даргад Сэдэд, Балдан, Гомбо, Түдэв, Сэрээтэр, Дэмбэрэл, Лувсанжамц, Очир нарыг тус тус тохоон тавь”¹⁸

хэмээн Эрдэнэ шанзудба нарт харъяат дарга нарыг тушаасан байна.

Мөн бүгдийн дарга, дэд дарга нарыг Дээрхийн хишигт мөргүүлэн, Дотоод

¹³ МУУТА, ХА-3, Д-1, ХН-292, нуг 16.

¹⁴ Мөн дээрх.

¹⁵ Мөн дээрх.

¹⁶ Мөн дээрх.

¹⁷ МУУТА, ХА-3, Д-1, ХН-292, нуг 15.

¹⁸ Мөн дээрх.

яамнаа ирүүлж бүгдийн даргын тамга хүлээлгэн өгсөн байна.

Ийнхүү 1912 оны өвлийн сүүл сарын 22-нд (1912.2.10) Их шавийн Эрдэнэ шанзудбын яамны харъяа Бүгдийн даргын газрууд байгуулагдсан байна. Бүгдийн даргын албыг буй болгох тухай Богдхааны зарлиг 1911 оны өвлийн дунд сарын шинийн 9-нд (1911.12.29) буусан билээ. Үүнээс үзэхэд 43 хоногийн дотор эл хэргийг хийж гүйцэлдүүлжээ. Нийслэл Хүрээний өмнө зүгийн шавийг захирах Бүгдийн дарга Пунцаг, дэд дарга Гомбо нар нэг өдрийн дараа Эрдэнэ шанзудбын яаманд өргөсөн бичигт,

“... Өвлийн сүүл сарын 22 Дээрхийн хишигт мөргөж мөнхүү өдрийн дотор ДХБЗШЯ-наас уламжлан шагнасан Хүрээний өмнө зүгийн шавь нарыг захирах бүгдийн даргын тамгийг боол Пунцаг биеэр хүлээн залж нээх хэрэглэсэн”¹⁹

хэмээн мэдүүлсэн байна. Чингээд найман зүгийн бүгдийн дарга нарт, Хүрээний Дорно этгээдийн шавь нарыг захирах даргын тамга, Хүрээний Дорно өмнө этгээдийн шавь нарыг захирах даргын тамга, Хүрээний Өмнө этгээдийн шавь нарыг захирах даргын тамга, Хүрээний Өрнө өмнө этгээдийн шавь нарыг захирах даргын тамга, Хүрээний Өрнө умар этгээдийн шавь нарыг захирах даргын тамга, Хүрээний Умард этгээдийн шавь нарыг захирах даргын тамга, Хүрээний Дорно умар этгээдийн шавь нарыг захирах даргын тамгыг²⁰ тус тус олгосон байна.

Мөн бүгдийн даргын тамгын газрын дүрэм хэмжээг батлан гаргасан байна.²¹ (Хавсралт үзнэ үү) Дүрэм нь 12 зүйлтэй бүгдийн дарга нарын эрх хэмжээг, тамгын газрын орон тоо, ажлын хөлс, явуулах үйл ажиллагааны чиглэл, тамгын газрыг хаана байгуулах зэргийг заан өгчээ. Жишээ нь, “Зүүн зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Бор-Өндөрийн хурлын газар байгуулах, Зүүн өмнө зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Хөхөлийн суурин газар байгуулах”²² гэх мэтээр төв хүрээ, сүм хурлын суурин газруудыг сонгон байгуулсан ч нэг газраа удаан суурин байсангүй. Эрдэнэ шанзудбын яамны тушааснаар нутаг сэлгэн нүүлгэж байжээ. Энэ нь Бүгдийн даргын тамгын газраар дамжуулан харъяа олон отог багуудтай ойртон ажиллахад, аливаа асуудлыг богино хугацаанд шийдэхэд чиглэж байсан бололтой. Тухайлбал өмнө зүгийн шавь нарын захирах тамгын жасааг анх Зогсоол хурлын газар²³ байгуулсан бол жасаа байгуулах шинэ газар сонгохдоо ойролцоох өртөө, ба Нийслэл Хүрээнээс хир хол болох, бичиг хүргэх отгийн дарга нарын ойрыг үзэн, ойролцоох отгийн шавь нар улаа

¹⁹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-779, нуг 1.

²⁰ МУУТА. ХА-74, Д-1, ХН-779, нуг 12.

²¹ Мөн дээрх.

²² МУУТА. ХА-74, Д-1, ХН-779, нуг 2.

²³ Мөн дээрх.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

залгах унаа морьтой эсэхийг шавь нарын нутаглах газрын бэлчээр усны байдлыг хүртэл харгалзан үзэж, “Манзушир ламын Буяныг залбирагч сүмээс ургаш отог олны дундыг үзэж”²⁴ байгуулахаар нутаг сонгож, “Нийслэл хүрээний зүгт буй Сэцэн хан аймгийн сум Цагаанчулуут өртөөний зүг”²⁵ байгуулья хэмээн Эрдэнэ шанзудбын яамнаа өргөсөн нэгэн баримт байна. Жасаа тамгын гэрүүдийг Эрдэнэ шанзудбын яамнаас бэлтгэж өгсөн байна.

Бүгдийн даргын тамгын газар нь тус зүг дэх олон отог багуудыг захирна. Жишээ нь, Зүүн өмнө зүгийн шавь нарыг захирах бүгдийн даргын газар 1912 оны байдлаар 14 отог, багтай байжээ. Тэднийг нэрлэвээс, Эрхийн дарга Манлажавын отог 483, Бүүвэй дарга Дамдинсүрэний отог 606, Шинэ дарга Арсланчүлтэмийн отог 241, Хувилгаан цоржийн дарга Цэндийн отог 203, Эрхийн дарга Бүтэмжийн отог 570, Манзуширын дарга Дэндэвийн отог 1739, Эрдэнэ хувилгааны дарга Мөрдэндэвийн отог 308, Мэргэний дарга Мөрдэндэвийн отог 604, Хичээнгүйн дарга Цэрэндэвийн отог 374, Говийн дарга Балжирийн отог 76, Говийн дарга Пүрэвийн отог 91, Говийн дарга Содномцэрэнгийн отог 109, Данжуурын дарга Ванчигийн отог 112, Санду сумын шүүлэнгэ Цэндийн отог 147 хүн амтай байв.

Дээрх бүгдийн даргын газар нь нийт 5663 хүн амтайгаас, хувраг 1890, эрэгтэй 50-иас дээш насны эр 220, 50-18 насны 290, 18-0 насны 233, эмэгтэйчүүд 3030²⁶ байгаагаас харвал нийт хүн амын 53,5 % эмэгтэй, 46,5% эрэгтэй эрчүүдийн 60,7% нь хувраг байжээ. Мөн Баруун хойд зүгийн шавь нарыг захирах бүгдийн даргын газарт 11 отог, 6 баг, харъяат газар орших хурал сүмийн газрууд болох Эрдэнэ номун ханы хүрээ, Соёлыг илэрхийлэгч сүм, Дэчиннамдалин сүм, Ширээ уулын Дашдаржаалин хийд²⁷-ийн газрыг харъяалан захирч байжээ. Харъяат отгууд харилцан адилгүй хүн амтай байгаа нь отог багуудын нутгийн хол ойроос шалтгаалж байсан болов уу хэмээн үзлээ. Говийн отогууд цөөн хүн амтай боловч хэд хэдэн даргад захирагдаж байгаа нь нэг даргад захирагдах боломжгүй алс зайтай нутаглах учир ойр нутаглахыг нэг отог болгон дарга, шүүлэнгээр захируулж байсантай холбоотой. Хамгийн олон хүн амтай Манзуширын отог²⁸ Нийслэл Хүрээтэй, Манзушир хутагтын Буяныг залбирагч сүмтэй ойр нутагтай.

Бүгдийн даргын тамгын газар нь бүгдийн дарга, дэд даргаас гадна отог багуудаас жасаалан суух зайсан түшмэд, зарлага хиа, зам, усч, түлээч, хэрэгтний дарга, хуягууд гэсэн албаны хүмүүсээс бүрдэж байжээ. Эдгээр албаны хүмүүсийг бүгдийн дарга нар дүрмийн ёсоор өөрийн зүгийн отог багуудаас сонгон авч

²⁴ МУУТА. ХА-74, Д-1, ХН-779, нуг 25.

²⁵ Мөн дээрх.

²⁶ МУУТА. ХА-74, Д-1, ХН-67.

²⁷ МУУТА. ХА-74, Д-1, ХН-157.

²⁸ Манзуширын отог нь Түшээт хан аймгийн Дархан Чин Ван Пунцагцэрэнгийн хошууны нутагт одоогийн Төв аймгийн Сэргэлэн, Баянцагаан сумын нутгаар нутаглаж байжээ. Энэ мэт Их шавийн олон отог багууд Халхын 42 хошууны нутагт нутаглаж байсан хэмээн О. Пүрэв Монгол улсын түүхэн газар зүй номондоо бичсэн байдаг. Пүрэв О, *Монгол улсын түүхэн газар зүй*, УБ, 2009, 40-43.

ажиллуулдаг журамтай байв. Тухайлбал, “...Гариачны дарга Сосорын отгоос түшмэл зайсан Луузан, бага хиа Хайдав, Буянт, Чоегийн дарга Лувсанбалданы отгоос түшмэл зайсан Цэдэвсүрэн, Лувсанжанцан, бага хиа Тогооч”²⁹, мөн Зүүн хойд зүгийн бүгдийн даргын тамгын газарт, “... хавар зуны цаг суух зайсан лам Сономпил, Дамдин, намар өвлийн цагт суух Дархан эмчийн зайсан лам Лувсанцэрэн, Лхамжав”³⁰ гэх мэт тэмдэглэсэн байх тул албаны хүмүүсийн бүртгэлийг авч тамгын газраа 6 сараар жасаалан суулгадаг байжээ. Тийнхүү Эрдэнэ шанзудбын яамнаас тамгын газар ажиллах хүмүүст хишиг өгөх байсан тухай, “... бүгдийн дарга нарт тусгайлан хүртэх хишиг буй”³¹...нэг жилийн мөнгийг Нийслэл хүрээний газар хүн илгээн авхуулсугай”³² хэмээсэн байх тул алба хаасны хөлс өгч байжээ. Гэвч хичнээн хэмжээний хишиг өгч байсныг харуулах баримтыг би олж үзсэнгүй. Харин доод албаны хүмүүст дүрмийн ёсоор,

“...дэд дарга нарыг түшмэл адилтгаж тамгын жасаанаа суух зайсангуудын хамт түшмэл нэг хүнд өдөр тутам 60 шар цай, бичээчид өдөр тутам 45 шар цай, зарлага хиа, зам, усч, түлээч, хэрэгтний дарга, хуягуудад нэг адил өдөр тутам 35 шар цай бодож хүнс олго”³³

хэмээсний дагуу цалин хөлс олгодог байжээ. Түүнээс гадна харъяат отог багуудаас тамгын газраа хэрэглэх, “...уяа морийг уяа тутам хоёроор төсөвлөж нэг жилийн эцэст хааяа илүү сарыг тооцож бүгд 52 морийг нижгээд сараар аргал ус зөөх үхэр тэргийг 12—ыг тогтоосон тоо болгож уг зүйлийг отог багуудаас нийгэмчлэн”³⁴ гаргуулж байв. Олноо Өргөгдсөн гуравдугаар онд (1913) Сар шинээр Богд эзэн гэгээн, Эх дагины амгаланг биеэр айлтгахад, бүгдийн дарга тайж Намжилдэв, Лувсанцэрэн, Пунцаг, Сүндэв, Сэрээтэр, Дэмбэрэл, Доржпалам, Лувсандорж³⁵ нар амгаланг айлтгаж хүндэтгэл үзүүлсэн байдаг.

Бүгдийн дарга, дэд дарга нар тусгайлсан ёслолын өмсгөлтэй. Тэргүүн зэргээс тавдугаар зэрэг хүртэлх жинхэнэ тушаалын түшмэдийн ёслолын өдөр өмсөх хүрэм фүс³⁶ зэргийг Дотоод яамнаас ёсчлон заан өгсөний дагуу 7 цуны дөрвөлжин фүс дээр тэргүүн зэрэг түшмэдийн өмнө ард таван нүд, дэд зэрэг түшмэдийн өмнө ард өлзий хээтэй фүс хэрэглэж байв³⁷. Ийнхүү бүгдийн дарга нар нь төрийн хар хүмүүний адил жинс, фүүс хэрэглэх болжээ. Тамга бүхий бүгдийн дарга нарын ёст малгайн жинсэнд артай алтан суурь оройд шүр хадсан байна. Мөн бүгдийн дарга нар Цэргийн хэрэглэл буюу орд сүм шинэтгэн байгуулах зэрэгт мөнгө, мал

²⁹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-146.

³⁰ МУУТА. ХА-74, Д-1, ХН-163, нуг 25.

³¹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-779, нуг 12.

³² МУУТА. ХА-74, Д-1, ХН-169, 4.

³³ МУУТА. ХА-74, Д-1, ХН-779, нуг 12.

³⁴ Мөн дээрх.

³⁵ МУУТА. ХА-3, Д-1, ХН-292, нуг 81.

³⁶ МУУТА. ХА-74, Д-1, ХН-163, нуг 18.

³⁷ Мөн дээрх.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь (1911-1915)

тусласныг сайшаан хөхүүлэх тухай тогтоосон дүрэм³⁸-д дараах мэт заажээ.

“...тамга бүхий бүгдийн дарга нар 50 лан мөнгө бариваас нэгэн тэмдэглэсэн зэрэг, 100 лан туслан бариваас хоёр тэмдэглэсэн зэрэг, 150 лан туслан бариваас гурван тэмдэглэсэн зэрэг, 200 лан туслан бариваас нэгэн нэмсэн зэрэг, 400 лан туслан бариваас хоёр нэмсэн зэрэг, 800 лан туслан бариваас нэгэн нүдний тогосын отго, 1600 лан туслан бариваас харавтар улаан өнгийн залаа шагнан олгоно. 4000 лан туслан бариваас өөр өөрийн нэжгээд зэрэг нэмэн дэвшүүлнэ.”

Таван мянган лан туслан бариваас дэвшүүлэн зэргийг үе улиран залгамжлуулан шагнан олгох дүрэм³⁹-ийн ёсоор бүгдийн дарга нар бусад хар, шар ноёдын нэгэн адил Улсын санд мөнгө хандивлан зэрэг зиндаагаа ахиулах боломжтой байсан байна. Бүгдийн дарга, дэд дарга нар хутагтын шавийн ёсоор заавал барих ёстой тахилын цайны албанаас чөлөөлсөн байна. Жишээлбэл, “Их санд цай зүйлийг барьдаг үгүй дандаа хэрэглэдэг ба бас отгуудаас цай, тос татан хэрэглэдэг лам нар эрхтэн” нарын дотор Намжилдэв, Лувсанцэрэн⁴⁰ нарын 16 бүгдийн дарга, дэд дарга нарын нэр бичигджээ. Ийнхүү найман зүгийн бүгдийн даргын газар байгуулагдан ажиллаж байжээ.

1911-1915 онд Их шавийн шавь нарын тоо хэрхэн нэмэгдсэн бэ гэдгийг харуулах мэдээ байна. Тухайлбал, 1912 оны байдлаар 6078 өрх, 36668⁴¹ ам байсан бол 1915 оны хүн амын тоогоор 6654 өрх, 38645⁴² амтай болж, 3 жилийн дотор их шавийн өрх 8,7%-иар, хүн ам 5,2%-иар нэмэгдсэн байна.

Эрдэнэ шанзудбын яамны нэгэн бичигт,

“...энэ завсар Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгаас манай шавьдшилжүүлэн захирсан Ноён ламын шавь сум, Асуд сум, Сөнөдзүүн засаг ван Магсаржаваас шавь болгон өргөсөн Цагаан овооны Буянаар ивээгч сүмийн шавь нар Дарьгангын таван гараас өргөсөн шавь нар, бас Манай гадаад Монголын төрийг дагаж харъяат шавьд хавсарган захируулсан Харчин Болдын этгээд өртөөний Толь сүмийн тойн хутагтын шавь нар бүгд 1000 өрх 5000 гаруй ам хүн их төлөв Халхын өмнө хязгаар Дотоод чуулган хошууны нутагт байгуулсан сүм хуралд татагдаж өөрийн өөрийн язгуурын идээшсэн газар нутаглан суух...”⁴³

хэмээжээ. Энэ мэт Монгол олон засаг хошуудаас шавь болох явдал 1915 оны Хиагтын гэрээ хүртэл тасралтгүй нэмэгдэж байжээ. Иймээс Эрдэнэ шанзудбын

³⁸ МУУТА. ХА-234, Д-1, ХН-34.

³⁹ МУУТА. ХА-234, Д-1, ХН-34.

⁴⁰ МУУТА. ХА-74, Д-1, ХН-152.

⁴¹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-48.

⁴² МУУТА. ХА-74, Д-1, ХН-327.

⁴³ МУУТА. ХА-3, Д-1, ХН-646, нуг 6.

яам шинээр бүгдийн даргын газар байгуулах саналыг Дотоод яам, Шашин төрд туслах яамны сайдуудад айлтгасанд, Нийслэл хүрээний өмнө замын зүүн, баруун этгээдээр хуваан захирах бүгдийн даргын газруудыг байгуулах⁴⁴-аар тогтон Богд хаанд айлтгаснаар. Олноо өргөгдсөний 5-р оны намрын тэргүүн сарын 18-нд (1915.8.15) Нийслэл Хүрээний өмнө замын зүүн этгээдийн шавь нарыг захирах бүгдийн даргын газрыг шинээр нэмэн байгуулж. Бүгдийн даргад Дотоод яамнаас айлтган зарлигаар Гонгоржав, дэд даргад Майдаржавыг тохоон⁴⁵...Нийслэл хүрээний өмнө замын зүүн этгээдийн шавь нарыг захирах бүгдийн даргын тамгыг намрын тэргүүн сарын 20-ны (1915.8.17) өдөр хүлээн⁴⁶ авч нээх хэрэглэсэн. Бүгдийн даргын тамгын жасааг ...Бодь амгалан сүмийн газар байгуулж Асууд шавь долоон отог, Аграмба ноён цоржийн шавь хоёр отог, Буяныг ивээгч түмэн өлзий сүмийн шавь нарыг захируулахаар тогтсоноор⁴⁷ есөн зүгийн бүгдийн даргын тамгын жасаа ажиллах болсон байна.

Бүгдийн дарга нараас нас барсан тохиолдолд дэд даргыг бүгдийн дарга болгож байжээ. Тухайлбал, Эрдэнэ шанзудбын яамнаас ДХБЗШЯ-наа өргөсөн нэгэн бичигт,

“...Нийслэл хүрээний баруун зүгийн шавь нарыг захирах бүгдийн дарга Гомбо өвчинөөр бие барсан явдлыг Дотоод яамнаа өргөн мэдүүлж бүгдийн даргын гарсан орыг сонгон тогтоохдоо баруун зүгийн шавь нарыг захирах бүгдийн дарга Гомбод дэд дарга Сэрээтэрийг тохуулж ...дэд даргад бага дарга Сономыг тохуул”⁴⁸

гэж байна. Ингэж бүгдийн даргын тамгын жасаад байгуулагдан ажиллах болсон.

Есөн зүгийн бүгдийн даргын тамгын газар нь Халхын нутаг дэвсгэрээр тархан суурьшиж, өсөн нэмэгдэж буй Хутагтын шавь нартай харилцах нүсэр ажлыг эмхлэн цэгцлэж, төр, шашны үйл ажиллагааг дөхөм хялбар болгохын хамт, төрийн бодлого чиглэл, үйл ажиллагаа хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн шинэчлэл байв.

Бүгдийн даргын тамгын жасаадыг байгуулсанаар засаг захиргааны нэг шинэ өөрчлөлт буюу тодорхой хил нутаггүй хошуудыг буй болжээ. Мөн бүгдийн даргын жасааг аймаг бүрт хошууны адил байгуулсан нь шашныхан өөрсдийгөө засаг тайж нартай зэрэгцүүлэн тавьсаны нэг илрэл болов уу.

⁴⁴ МУУТА. ХА-3, Д-1, ХН-646, нуг 1.

⁴⁵ Мөн дээрх.

⁴⁶ МУУТА. ХА-74, Д-1, ХН-1094, нуг 1.

⁴⁷ МУУТА. ХА-74, Д-1, ХН-1094, нуг 14

⁴⁸ МУУТА. ХА-74, Д-1, ХН-107, нуг 73.

2. Бүгдийн даргын тамгын газрын үйл ажиллагаа

Бүгдийн дарга нарын тамгын газрын үйл ажиллагааг Эрдэнэ шанзудбын яам шууд удирдан захирдаг. Эрдэнэ шанзудвын яам болон ДХБЗШЯ болон бусад яамдын гаргасан шийдвэрийг өөрийн харъяат отог багуудад хүргэж даган мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлэх, гүйцэтгүүлэх үүрэгтэй байжээ. Эл зүйл нь Бүгдийн даргын дүрэмд тусгагджээ. Тухайлбал, Бүгдийн дарга нарын эрх үүргийг дүрэмд, Эрдэнэ шанзудбын яамтай шууд харилцан, өөрийн харъяа отог багийн бүх шавь нарыг захирах, Засгийн хэргийг зөвлөх, шийтгэх эрх өгсөн, Шүүх эрхтэй. Энд аар саар хулгай худал шийдвэрлэх, торгох, будлиан ихтэй болбол Эрдэнэ шанзудбын яам болон, харъяа Чуулган дарга нарт шилжүүлэх, Өөрийн бүгдийн даргын тамгын жасанд ажиллах түшмэл бичээч зэрэг албаны хүн нарыг сонгох, Албаны хэргийн тул улаа хэрэглэн нааш цааш явах зардал мөнгө хоол хүнсийг мөн Доод тушаалын албаны хүн нарын өдөр ажиллах хөлс мөнгийг бүгдийн даргын тамганд хуримтлагдсан мөнгөнөөс гаргаж өгч жилийн эцэст Эрдэнэ шанзудбын яамнаа мэдүүлэх, Албаны хэргийн тул нааш цааш явахад дагалдах 3 хүнийг дагуулж явах эрхтэй, Шавь ардаас санд барих тахилын цайны албыг, өр авлагыг шаардан гаргуулах, Бүгдийн дарга нар албаны хэргээр өөрийн отог нутгаас гарч явах, бие өвдөх элдэв гачаал гарваас чөлөө хүсэн мэдүүлж тамгаа дэддаргад шилжүүлнэ гэх мэтчилэн журамлан өгчээ.

Дээр дурьдсан эрхийн дагуу бүгдийн дарга, дэддарга нарын үйл ажиллагааны гол чиглэл нь харъяат отог багуудаас олон зүйлийн алба татвар гаргуулахад оршиж байжээ. Мөн Богд хааны лүндэн, төрийн яамдаас гаргасан шийдвэрийг харъяа отог багуудад танилцуулах, хэрэгжүүлэх явдал байсан байна.

Жибзундамба хутагтын шавь нар Олноо Өргөгдсөний 2-р оны 9 сарын 14-ны (1912) Бүгд Ерөнхийлөн захирах сайд нарын,

“...Өндөр Богдын үеэс эхлэн харъяат олон шавь нарын хөрөнгөнд өргөл тахилын цай ба бурхан номын үйлдвэрийн хэрэглэлээс өөр алба гаргуулсан зүйл үгүй ...хуучин ёсыг журамлан уул дагнаж өргөх тахил бурхан номын хэрэглэлийг хэвээр гаргуул”⁴⁹

хэмээх тушаал ёсоор Богдгэгээн болон Их шавийн харъяа сүм хийдүүдийн хурал ном, шавийн захиргааны зардал хэрэглэлийг гаргадаг байв. Үүнийг тахилын цайны алба⁵⁰ гэж нэрлэдэг. Энэхүү алба хураах ажлыг,

“...найман зүгийн шавийг захирах бүгдийн дарга найман орыг байгуулж, алба хэргийг эрхлэн шийтгүүлсэнээс нааш тусгай түшмэл гаргах чирэгдэлийг

⁴⁹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-107, 46 .

⁵⁰ Тахилын цайны албыг дотор нь сэвэг сул хэмээн хоёр хуваах ба 800 ширхэгийн 1 сэвэг 800 үл хүрэхийг сул цай хэмээн отогын малчидын малын тоонд таацуулан алба оноодог.

арвилаж сандбарих албыг бүгдийн даргын газар шаардан хөөлгө⁵¹ хэмээгээд дүрэмд... Сандбарих аливаа албыг найман зүгийн бүгдийн даргын газраас элч гаргаж хөөн шаардуулж тус тусын отог багын дарга шүүлэнг нарын газраас өөрийн харъяат санд тусгайлан гарын тэмдэг бичиг авч өөр өөрийн бүгдийн даргын газар тушаан өгч нийлүүлэн буцаахад бэлтгүүл⁵²

гэснээр бүгдийн даргын газар нь харъяат олон отог багуудаас тахилын цай болон бусад албыг шаардан гаргуулах болжээ. Тухайлбал, Баруун хойд зүгийн шавь нарыг захирах бүгдийн даргын газрын Эрдэнэ номун ханы отогт Эрдэнэ шанзудбын яамнаас Олноо Өргөгдөсний 2-р онд (1912) оноон хуваасан алба тахилын 44 сэвэг цай, 200 сул цай, тос 6636 жин, сандсаалийн үнээ 54, даншигийн зоог зэрэг 6 зүйлийн үнэд хураах 34930 цай⁵³ хураалгах үүрэг хүлээжээ. Энэ мэтээр отог багуудад алба оноож тухайн отгын дарга шүүлэнг нар бүгдийн даргын жасаанд болзоот өдөр хүргэн ирж, бүгдийн дарга нар өөрийн отгуудын албыг бүрэн хүлээн авч Эрдэнэ шанзудбын яамны сангийн хэргийг эрхлэсэн түшмэлд хүлээлгэн өгөх үүрэгтэй байв. Гэсэн хэдий ч отог багуудаас албаа тогтоосон хугацаанд өгч чадалгүй хоцрох, шаардуулах зүйл их гардаг байв. Эрдэнэ шанзудбын яамны нэгэн бичигт,

“...харъяат дарга нар огт хайхрах үгүй алба тасалдуулж манай газраас бичиг залан гаргуулж шаардуулсаар боловч хэвээр дарагдуулан тасалдуулж одоо санд зарцуулах мөнгө цай огт үгүй өдөр өдөр хэрэглэх зүйл шууд тасалдахад хүрэв хэмээн нярав нар байн байн мэдүүлэх ...энэ нь бүгдийн даргын захиран шийтгэх нь осол сул энэхүү зүйлийг чангалан нарийвчлан байцаа.”⁵⁴

хэмээснээр Өмнө зүгийн бүгдийн дарга нараас, Их сандөр дутуулж хугацаа бүхий болзооноос эс гүйцээсэн тус зүгийн харъяат захирах отог багын дарга, шүүлэнг нараас заримыг нь чангалан барин хүргүүлсэн⁵⁵ мөн өртэй отгуудын дутууг аль сард барьж дуусахыг тогтох зэргээр ажиллаж байжээ. Бүгдийн дарга нар нь Эрдэнэ шанзудбын яамны заавар ёсоор,

“... Зүүн өмнө зүгийн бүгдийн дарга Лувсанцэрэн, Намжилдэв нарт түшмэд зайсан Магсаржав нарыг тусгаар отог болгож Гэлэгбаатарыг даргад тохоон шилжүүлэн захирч тэдний отгийн ардад тогтоол алба буй аваас түүгээр шилжүүлж гүйцэтгүүлэх”⁵⁶

⁵¹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-54.

⁵² МУУТА. ХА-74, Д-1, ХН-779, нуг 12.

⁵³ Мөн дээрх.

⁵⁴ МУУТА. ХА-74, Д-1, ХН-110, нуг 29.

⁵⁵ МУУТА. ХА-74, Д-1, ХН-165, 24.

⁵⁶ МУУТА. ХА-74, Д-1, ХН-107, нуг 9.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

болж, шинэ отог таслан гаргах, отог хоорондын шилжих хөдөлгөөнийг зохицуулж байв. Жишээ нь,

“... зүүн өмнө зүгийн бүгдийн даргын газраас Хэрлэний дарга Дагдангийн отгийн хар Дэмбэрэл Очир нар харъяат дарга нар дарлагдаж отогт алба залгамжуулуулан явж чадахгүй тул ...Тавнангийн дарга Цэрэндондовын отог шилжүүлэн захируулмой хэмээн мэдэгдсэнийг ... айлтгасан ёсоор болгон шилжүүлэв. Дэмбэрэл хувраг 1, өрх 1, ам 7, тахилын цай 360 сул, Очир хувраг 1, ам 5, хамтаар шилжүүлэв”⁵⁷

гэх мэтээр отог багын шавь нар тэдний алба татвартай холбоотой олон асуудлыг шийтгэж байжээ.

Мөн Богд хаанд Бат-Оршил өргөж, даншиг наадам, Түмэн амгалан айлтгах зэрэг олон баяр ёслолд биеэр оролдох, баярын үеэр хэрэглэх зардалыг хуваасан ёсоор отог багуудаас гаргуулах, өөрийн харъяа хутагт хувилгаад нарт зарлан биеэр оролцуулах, чөлөө олгож цааш мэдүүлэх олон ажлыг гүйцэтгэж байв. Тухайлбал, 1912 онд Богд хаанд Бат-Оршил өргөж, наадам хийхэд, “...зүүн хойд зүгийн бүгдийн дарга Лувсандоржоос харъяат зүг дэх Дара эх даянч хувилгаан Чойжижанцан бие өвчтэй учир Бат-Оршил өргөхөд бараалхаж чадахгүй учир уламжлан мэдүүлжээ”⁵⁸. Бүгдийн даргын газрууд ...уралдах мориноос бусад ...бөх, харваач ба бие хуралд хэрэглэх цай зүйлийг хуучин хэвээр олон шавь нар 100 цайд 7 шар цай хуваан томилож биеэр хураах зүйлүүдийг гарга⁵⁹ гэсний дагуу Нийслэл Хүрээний өмнө зүгийн шавь нарыг захирах бүгдийн даргын харъяа отог багуудаас дээрх зүйлүүдийг гаргасан нь дараах мэт болно.

Бүгдийн даргын газрууд Богд хааны айлдсан лүндэн, бурхны ном зэргийг отог, багын айл бүрт тараах, Нийслэл Хүрээний газар түмэн гэлэнгийн хайлан хурах, Дүйнхорын лойлон бүтээх зэрэг бурхан шашны холбоотой явагдаж буй ажлыг отог багуудад таниулах, оролцуулах ажлыг хийдэг байсан байна. Тухайлбал, Богд хааны лүндэнгээр жил бүр хуруулах түмэн гэлэнгийн хайлаанд, ...энэ жил гэлэн гэцэл түмэн тоонд хүргэж хайлаан хийлгэхэд одоо Нийслэл хүрээнд 3000 гаруй хүнийг дайлан гаргаж үлдсэнийг нь аймаг, шавь тав хуваан оноох⁶⁰ гэсний дагуу бүгдийн дарга нар харъяат отог, баг, сүм хурлын газруудаас хуврагуудыг явуул гэсний дагуу жишээлбэл, ...Тавнангийн дарга Цэрэндэндэвийн отгоос гэлэн Гончиг, Дэндэв, Наваан-Иш⁶¹ гэх мэт 18 хүнийг явуулахын хамт хайланд хэрэглэх зүйлийг зүг бүрийн бүгдийн дарга нарын газар хуваахад, Өмнө зүгийн шавь нарыг

⁵⁷ МУУТА. ХА-74, Д-1, ХН-836, нуг 33.

⁵⁸ МУУТА. ХА-74, Д-1, ХН-165, нуг 22.

⁵⁹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-110, нуг 8.

⁶⁰ МУУТА. ХА-74, Д-1, ХН-163, нуг 12.

⁶¹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-358, 20.

захирах бүгдийн даргын газрын отгуудаас гаргасан зүйл нь Хүснэгт 2 болно.

Хүснэгт 1.⁶²

Отог	Мэргэний отог	Хичээнгүйн отог	Манзушир отог	Бүүвэй отог	Эрх отог	Эрдэнэ хувилгаан отог	Хувилгаан цоржийн отог	Шинэ отог	Говь отог	Мөн отог	Сант сум
30 хоногийн унд хүнстэй сонгогдсон сайн бөх	4	4	6	3	3	3	2	-	-	-	-
Адил хэрэглэлтэй сайн харваач	2	2	2	2	2	1	1	2	-	1	-
Шуудай цагаан идээ	1	3	1	1	1	2	1	1	1	-	1
Амттай сайн ваар арз	1	2	1	2	1	1		1	-	-	-
Хүрээний газар ирүүлэх морь (айраг)	2	2	1	1		2	2	2	-	-	-
Бие биеэр шар цай	1026	738	3836	1470	1476	1207	957	355	176	181	70

Хүснэгт 2⁶³.

Отог	Мэргэн Отог	Хичээнгүйн отог	Манзушир отог	Бүүвэй Отог	Эрх отог	Мөн отог	Эрдэнэ хувилгаан Отог	Хувилгаан цорж отог	Шинэ отог
Үнээний тоо	6	4	23	9	9	0	7	2	2
Өдөр бүр барих сүү жин	18	12	69	27	27	0	21	6	6
Аарц жин	2748	2187	10204	4030	3955	2016	3234	923	950

Бүгдийн дарга нарын газраас 1913 онд Нийслэл Хүрээнд Дүйнхорын лойлон бүтээхэд,

“...Баруун хойд зүгийн шавь нарыг захирах бүгдийн дарга Дэмбэрэл нарын харьяат захирах 19 отог багууд...хувилгаад ба хүрээ сум хийдийн газрууд Нийслэл хүрээний газар Дүйнхорын лойлон бүтээхэд мөнгө 26 лан, 100 тоог цаас хэмээн бодсон улаан мөнгө 695, соном хадаг 176, даш хадаг 529⁶⁴

⁶² Мөн дээрх.

⁶³ МУУТА. ХА-74, Д-1, ХН-110, нуг 15.

⁶⁴ МУУТА. ХА-74, Д-1, ХН-157.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

зэрэг зүйлүүдийг олон бүгдээр хандив өргөхөд хүлээн авч тэмдэглэл хөтлөн хүргэн ирүүлэх ажлыг гүйцэтгэжээ.

Бүгдийн даргын газар нь Сангийн Хамаг Хэргийг Бүгд Захиран Шийтгэх Яам, Гаалийн Хэргийг Ерөнхийлөн Шийтгэх Яамтай нийлэн гаргасан дүрэм зааварт заасны дагуу гааль хураах ажлыг гүйцэтгэж байсан байна. Гаалийн Хэргийг Ерөнхийлөн Шийтгэх Яамнаас,

“...олон харъяатгазраас гаалийн мөнгөнд цаасны үнийг харилцан адил үгүй бодож хүргүүлэх нь буй ...Орос улсын цөлхөөв цаас хүргүүлэх аваас цаас нэг бүрийг мөнгө 7 цэнд таацуулан бодож хүргүүлвээс зохих”⁶⁵

хэмээсэн ёсоор Шавьд худалдаа наймаа эрхлэгчдээс гааль хураах ажлыг гүйцэтгэж байжээ. Баримтанд, “манай газраас харъяат Бүгдийн дарга нарын газар гааль хураах эсэх явдлыг өөрөө мэдүүлэхээр зөвшсөн уг хэргийг журамлан дагах хэмээгээд тэмдэгт хуудас 186 олгох”⁶⁶ гэснээр Баруун зүгийн шавийг захирах дэд дарга Намсрайн бичигт “7 сарын 17 нд гааль хураах тэмдэгт бичиг хүлээн авлаа. Энэ завсар гааль хураасан огт үгүй”⁶⁷, мөн “манай бүгдийн даргын газраас энэ гурван сард хураасан гаалийн мөнгө 24 лан, 2 цэн, 4 пунг 10 хувь бодож шимтгэх 2 хувийн 4 лан 8 цэн 4 пун 8 ли тайлаад, хураасан цаас 27 мөнгө 69-ийг нэгэн анги бодож”⁶⁸ хэмээснээс тодорхой байна. Гааль хураах дүрэмд заасны дагуу “хураасан гаалийг 10 хувь бодож, 2 хувь -ийг уул газар шимтгэн олгуул”⁶⁹ хэмээсэн ёсоор хураасан гаалийн 2 хувийг бүгдийн даргын газраар дамжуулан Эрдэнэ шанзудбын яаманд тушаадаг байсан болов уу. Энэ гаалийн татвар мэдээж Монгол улсын санд орж байсан бөгөөд улсын төсөв бүрдүүлэхэд зохих хувь нэмэр оруулж байсан бололтой. Энэ үед худалдаж борлуулах зүйлд 5 хувийн хураамж ногдуулж байсан билээ.

Богд хааны лүндэнд,

“...наадам наадах, архи тамхи татах, лам нар эмс охид лугаа самууран явах шарын шашны олон нийтэд харш зүйлийг тус тус отог баг дотор цаг үргэлж цагдан байцааж, зөрчин явагчид байваас цагдан байцааж тамгын газар хүргүүл үл тоох аваас харъяат дарга шүүлэнг дэмч ажиг нарыг хүнддэн шийтгэ”⁷⁰

хэмээсэн ёсоор шүүх эрх мэдэлтэй байсан байна. Дүрэм хэмжээнд заасан ёсоор хөнгөн хэргийг торгох, ташуурдах, дөнгөлөх, гинжлэх зэргээр шийтгэнэ.

⁶⁵ МУУТА. ХА-74, Д-1, ХН-110, нуг 15.

⁶⁶ Мөн дээрх.

⁶⁷ МУУТА. ХА-74, Д-1, ХН-165, 122.

⁶⁸ МУУТА. ХА-74, Д-1, ХН-358, 13.

⁶⁹ МУУТА. ХА-9, Д-1, ХН-36, нуг 1

⁷⁰ МУУТА. ХА-74, Д-1, ХН-110, нуг 15.

Бүгд Ерөнхийлөн шийтгэх яамнаас, “архи худалдах ба авахыг нийтээр цаазалж журамлан дага”⁷¹ гэсний дагуу Манзуширын дарга Зодовын отгийн шавь Наваансүдсорыг архи уун согтууран албаны газар авирласан хэрэгт өдөр дөнгө дөнгөлж, ташуур занчиж шийтгэсэн⁷², Эрхийн дарга Цэрэндондов отгийн шавь Алтангэрэл харъяат газрын албаны тамгын бичээч, ажлаа санаатай тасалдууж будилантуулсан тул гурван ёс малаар торгож шийтгэсэн⁷³ байх тул эдгээр хэргийг Нийслэл хүрээний өмнө зүгийн шавь нарыг захирах бүгдийн дарга шийтгэсэн байна. Лам хуврагуудын ёс зүй, сахилгын асуудлыг мөн нэгэн адил журамлаж байжээ. Ийнхүү Бүгдийн даргын тамгын газрын эрх хэмжээнд энэ мэт олон хэргийг шийдэн зохицуулдаг байжээ.

3. Бүгдийн даргын газрыг татан буулгасан нь

1915 онд Орос-Монгол-Хятадгурван этгээдийн Хиэгтын гэрээгээр Монгол улсыг Хятадын эзэн эрхийн дор автономит эрхтэй орших улс болгон бүрэн эрхт байдлыг хязгаарласны дараа Улсын төсөв мөнгийг хэмнэх үүднээс зарим нэгэн арга хэмжээг авсан юм.

Шинэ тулгар төрөө байгуулсан Монгол улс нь санхүү эдийн засгийн хувьд хүнд хэцүү байсан юм. Монгол улс нь эдийн засгийн хувьд Хаант Орос болон ДИУ-ын бүрэн хараат байдалтай байлаа. Тухайлбал, 1911 оны эцсээр Халхаас Дайчин улсын банкинд төлөх өр 800 мянган гаран лан мөнгө⁷⁴ байсан. Мөн 1913 онд Намнансүрэн Орост айлчилж 3 сая рубль⁷⁵ болон зэр зэвсгийн зээл авахыг хүссэнд, Хаант Орос улсын засгийн газраас Монголын засгийн газрын саналыг хүлээн авч, 3 сая рубль олгохыг зөвшөөрөөд түүнийг 30 жилд багтаан төлөх бөгөөд эхний удаа 2 саяыг 2000 винтов, 6 их буу, 4 пулемонт сум хэрэглэлийн хамтаар олгосноор⁷⁶ Монгол улс их хэмжээний өртэй болов. Мөн улсын төсөв мөнгө 1911-1919 онд байнга алдагдалтай байсныг судлаач З. Лонжид, зөвхөн төрийн албан хаагчдад олгож байсан цалингаар жишээ аван өгүүлсэн буй. Үүнд, Богд эзэн Улсын эх дагина нар тус бүр жилд 36000 лан мөнгө, ерөнхий сайд Намнансүрэн 5000 лан, халхын дөрвөн хан 5 хүнд 2500 лан, төрийн таван яамны тэргүүн сайд нар 205 лан, дэд сайд 14 хүн 162 лан 5 цэн ... ван гүнгүүдэд олгох цалин Ханддоржид 4000 лан, Чин ванд 2000 лан, Жүн ванд 1200 лан, Бэйлд 800, Бэйс 500 лан, Улсын түшээ гүнд 300 лан, Улсад туслагч гүнд 200 лан, Засаг тэргүүн зэрэг тайжид 100

⁷¹ МУУТА. ХА-74, Д-1, ХН-77, 10.

⁷² Урангуа Ж, Баярсайхан Б. *Жинхэнэ дагаж явах хууль дүрэм 1913-1918*, Эх бичгийн судалгаа, УБ, 2005, 68.

⁷³ Мөн дээрх.

⁷⁴ Лонжид З, *Монгол улсын санхүүгийн албаны түүх* (1911-1921), УБ, 2000, 20.

⁷⁵ Мөн дээрх, 14.

⁷⁶ Мөн дээрх.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

лан⁷⁷ гэх мэтээр олон яамдын түшмэд нарт улсын сангаас цалин олгож байсан. Мөн 1913-1914 онд явуулсан Өвөр Монголын чөлөөх 5 замын байлдаан ч улсын санхүү эдийн засагт хүнд дарамт болсон зэрэг дээрх олон шалтгаануудын улмаас улсын төсөвийг хэмнэх нэрийн дор авсан арга хэмжээнд Бүгдийн даргын газар ч хамаарагдсан юм.

Нийслэл Хүрээний Хамба Номун хан, Эрдэнэ шанзудбын яамнаас Олноо Өргөгдсөн 5 оны (1915) өвлийн тэргүүн сарын шинийн 8-нд (1915.11.14) есөн зүгийн шавь нарыг захирах бүгдийн даргын тамгын газрыг татан буулгах асуудлыг Богд хаанд айлтгаж баталгаажуулсан байна. Татан буулгасан шалтгааныг дараах мэт тайлбарласан буй.

“... Монголчууд Дундад, Орос улс лугаа гэрээ бичиг хэлэлцэн тогтоож дотоод засгийн аливаа хэрэг зүйлд өөрөө дахин эзэрхэх эрхтэй болгочихуй энэ хир бүгдийн дарга нарын аливаа тамгын газраас элдэв хэрэглэх хүнс хэрэгсэл ба уналга ачлагын уяаны морь, тэмээ бас тэдний тамгын газраас элч нарын уналга зэрэг үлэмжхэн бөгөөд эдүүгээ элдэв цагийн гачаалаар олон шавь хөрөнгө чинээ маш ядуурч эрхэм чухал шашин хурал ба аливаа албаны зүйлийг тасалдуулхад хүрсэн зэрэг эл учрыг хянав⁷⁸

Мөн,

“Бүгд Ерөнхийлөн захирах яамнаас цагийг дагаж улсын санг арвилан харъяат ерөнхийлөх зэрэг гурван яамны тамгыг татаж яамыг хасаж өөр өөрийн эрхлэн шийтгэсэн хэрэг зүйлийг зохих газруудад шилжүүлэн тушаах ... зарлиг ёсоор болгон шийтгүүлсэн”⁷⁹

гэжээ. Энэ мэт шалтгааны улмаас есөн зүгийн шавь нарыг захирах бүгдийн дарга нарын тамгыг татан авч, Эрдэнэ шанзудбын яамнаа тамга, данс зэргийг шилжүүлэн хураалгаж албаны хэргийг хуучин ёсоор гүйцэтгэн шийтгүүлэхээр болжээ. Чингэхдээ ажил хэргээ эмхлэн цэгцлэх журам гаргаж бүгдийн дарга нарын газрыг тараасан байна. Энд тухайлбал,

- Аливаа зарга заальхай хулгай зэрэг хэргийг учир баригдаж сахиулсан хэрэгтэн нарыг шүүн шийтгэж дуусах
- Харъяат яамны галын гэр, олбог дэвсгэр, сав хэрэглэл, банз шаахай, гав тушаа, дөнгө, ташууг, хулгай хорих модон гэр зэргийг дансалж буцаан хураалгах
- Харъяат яамнаас торгон шийтгэсэн ба гаалийн шимтгэлээс хураан хадгалсан албан зүйлийн мөнгө хэдэн лан болхоос албанд зарцуулсан үлдсэн нь хэд болохыг нарийвчлан байцааж хураалгах
- Гаалийн яамнаас олгосон гаалийн хуудас бичиг хэд хэргэлсэн нь хэд, үлдсэн хэд болох гаалийн хураасан хуудас бичгийг хураасан мөнгийг дагалдуулан

⁷⁷ Мөн дээрх, 24.

⁷⁸ МУУТА. ХА-74, Д-1, ХН-1094, нуг 11.

⁷⁹ Мөн дээрх.

хүргүүлэх

- Харъяат тамгын газрын албаны уяа уях, аргал ус зөөхөд олгосон морь, тэмээг тоолж манай газраас гаргасан зайсан түшмэлийн хамт тоолж тоо ёсоор хураан авч харъяатшавийн хөрөнгө чинээ бүхий итгэвээс зохих хүнд тушаан хадгалуулах тухайн хүн аль отгын хэн болох хичээн тооны мал тавьсан явдалыг данс үйлдэж ирүүлэх
- Хөдөөний олон хутаг хувилгаад лам нар шинэ жилд дээдийн амгалан эрх, зун цагийн олон аймаг шавийн өргөх даншигт биеэр бараалхан ирж гүйцэтгэх, чөлөө гуйсан зэргийг бүгдийн дарга нараар мэдүүлж уламжлан явуулсан одоо эдгээр хэргийн Эрдэнэ шанзудбын яамнаа болзооны дотор мэдүүлэхийг зохих газруудад зарлах
- Дээд ордны зэрэг олон газар түлээ түлш, мөс зөөх шар үхрийг харъяатнайман зүгийн бүгдийн даргын газар хувааж тушаасан одоо чухам хэд хаана байгааг түшмэдэд тушаан өгч хүргэн ирүүл
- Дээрхээс бүгдийн даргын тамгын газраа залж тахиулсан бурхан шүтээнийг тус тусын бүгдийн дарга нарт залуулж тахиулах тул бурхан шүтээн хэрэглэлийг хуваан авч сайн сайхнаар тахиул⁸⁰ хэмээн журамлаж яамнаас зүг тус бүр байцаагч түшмэл гаргаж бүгдийн даргын тамгын жасаадуудыг хаалгасан байна.

Хиагтын гурван улсын гэрээгээр Өвөр Монголыг Дундад Иргэн улсын бүрэлдэхүүнд оруулсан учир сар хүрэхгүйн өмнө үйл ажиллагаа өргөжүүлэн Өвөр Монголын нутагт байх шавь нарыг захирах Өмнө замыг зүүн этгээдийн бүгдийн даргын газрыг ч татан буулгахад хүрчээ. Энэ тухайд нэгэн сонирхолтой баримтыг эш татваас,

“...Шилийн голын чуулганы Сөнидийн зүүн засаг Чин ван Магсаржав ...тамгатай бичиг гаргаж Очирдарь богд гэгээнээ шавь болгон өргөсөн Буянаар ивээсэн сүм Далай нүдэнгийн хурлын шавь хүн амыг татан авъя хэмээн мэдүүлсэнд манай Гадаад яамнаас гүн Магсаржавын дуртай Их шавьд өргөсөн сүмийн шавь нарыг дуртай татан авах хэмээснийг түдгэлзэсэн”⁸¹

хэмээсний шалтгаан нь тодорхойгүй байгааг цаашид гүнзгийрүүлэн судлууштай байна.

Эрдэнэ шанзудбын яам тархан нутагласан шавь нарыг захирах Бүгдийн даргын газар байгуулж, отог багуудтай харилцах үйл ажиллагаа ойртуулах, ажил хэргээ хялбарчлах үүднээс эл газрыг байгуулсан боловч отог шавийн ардууд ядуурснаас алба татвараа өгч чадахгүй Богдын сан хоосорлоо, сүм хийдийн хурал номын ажил тасарахад хүрлээ гэсэн олон бичгүүдийг Бүгдийн дарга нарын газруудад удаа дараа явуулан шаардаж, отог багуудаас олон оны алба татварын

⁸⁰ МУУТА. ХА-74, Д-1, ХН-1094, нуг 10.

⁸¹ МУУТА. ХА-3, Д-1, ХН-778.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

нэхэмжилж байсан зэрэг нь эл газар гол ажлаа төдийлөн сайн хийж чадахгүй байсантай холбоотой байж болох мэт боловч нөгөө талаар энэ нь Монголын нийгмийн байдалтай салшгүй холбоотой байсан аж. Төр, шашны захиргаа удирдлагын нүсэр бүтэц нь төрийн санхүүд томоохон дарамт учруулж байжээ. Иймээс 1915 оны 10 сарын 12 нд Дотоодын зэрэг олон яамны хамаг хэргийг захирах шийтгэх яам, Шашин төрд туслах сайдын яам, Гаалийн хэргийг ерөнхийлөн шийтгэх яамдыг татан буулгахын хамт 11 сарын 14 нд Эрдэнэ шанзудбын яамны харъяа есөн зүгийн бүгдийн даргын тамгын газрыг татан буулгажээ. Бүгдийн даргын газар нь 1912 оны 2 сарын 10 эхлэн 1915 оны 11 сарын 14-ны хооронд оршин тогтонон үйл ажиллагаа явуулж байжээ.

Бүгдийн даргын нийгэмд эзлэх байр суурийг тэр үеийн эх сурвалжуудыг харгуулан үзэж тогтоож болохоор байна. Аливаа хууль дүрэмд Монголын ихэс дээдэстэй холбоотой заалтуудыг бичихдээ дээд зиндааныхныг эхлэн бичиж доош нь уруудуулах маягаар бичиж тэмдэглэсэн байдаг. Архивийн баримтуудад, “...Аливаа засаг ба засаг бус улсын түшээ гүн, улсад туслагч гүн, засаг тэргүүн зэрэг тайж, тамга бүхий бүгдийн дарга” гэж бичсэн байдгаас үзэхэд, бүгдийн дарга нар нь, гүнгийн хэргэмтэй засаг болон засаг бус ноён, тэргүүн зэрэг тайж ноёны зиндаанд байжээ.

Олноо өргөдсөний эхний 5 жилд Богд хааны Их Шавийн зүг зүгийн хэргийг эрхлэх алба байгуулах санаа бүр Үндэсний эрх чөлөөний хувьсгал ялахаас өмнө бодож боловсруулсан зүйл байжээ. Тиймээс ч туурга тусгаар улсаа тунхаглан зарласан анхны өдөр буюу 1911 оны 12 сарын 29-ний өдрийн хааны зарлигт Бүгдийн даргын албыг буй болгох тухай зааж өгсөн байна. Бүгдийн даргын газар байгуулагдсанаар Халх нутагт тархан суусан олон отог багын зайсан дарга нараар удирдуулсан салангад үйл ажиллагааг төвлөрсөн нэгдмэл ажиллагаатай болгох, есөн нэмэгдэж буй шавь нарынхаа асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ байв. Монголын төрийн тэргүүн шашны хүн болсон нь тус оронд шашныхны нөлөө маш их болгоход хүргэсэн бөгөөд шар ноёдууд хар ноёдын нэгэн адил төрийн хэрэгт оролцох болж, чухал чухал албан тушаалд лам нар томилогдсон нь төрийн зүгээс тэдний эрх ашгийг хамгаалах бодлого идэвхитэй явуулах нэгэн хүчин зүйл болсон. Тухайлбал,

“... Хүрээний да лам Цэрэнчимэдэд ...Шадар сайд бүгд захирах сайд, Дотоод яамны хэргийг бүгд захиран шийтгэгч яамны тэргүүн сайдын тушаалд талбигтүн, мөн тус Шавийн харъяат эл албан хэргийг хавсран шийтгүүлэгтүн. ...зайсан лам Равданд хүрээний да лам, бас Гадаад яамны дэд сайдын тушаалд тохоон тавигтүн.”⁸²

хэмээж байжээ. Мөн 1912 онд Бүгд ерөнхийлөн шийтгэх яам буюу хэрэг дээрээ

⁸² МУУТА, ХА-3, Д-1, ХН-2.

ерөнхий сайдын албыг буй болгохын зэрэгцээгээр Шашин төрд туслах яам байгуулж, төрийн чухал хэрэгт томоохон мяндагтан лам нарын нэгэн шинэ яамыг байгуулсан билээ. Хойшид энэ яамны үйл ажиллагаа болон Эрдэнэшанзудбын яам болон эл хоёрын үйл ажиллагааны шүтэлцээг судлан гаргаж өгөх шаардлага ч байсаар байгаа билээ.

Дүгнэлт

Монгол улсын төрөөс улс төр, эдийн засаг, боловсролын салбарт олон шинэчлэл хийсний нэг нь бидний өгүүлж буй Их Шавийн зүг зүгийн хэргийг эрхлэн шийтгэн явуулах Бүгдын даргын газар мөн түүнд хамаарч байна. Бүгдийн дарга нар нь Засгийн ёсоор үйл ажиллагаагаа явуулж байсныхаа хувьд засаг төрд өндөр алба хашиж байгаа хар ноёдын нэгэн адил төрийн хэргэм, зэрэг, эрх ямба эдлэх болжээ.

Монголын шарын шашны тэргүүн Богд Жибзундамба хутагт Монголын хаан болсноор түүний шавь нар ч улс төрийн эрх мэдэл олж, зохион байгуулалтын шинэчлэлд орсон боловч тэр нь богино настай байжээ. Бүгдийн дарга байгуулсан нь Их шавийн засаг захиргааны уламжлалт нэгж отог багт чанд хяналт тогтоох шаардлагаас үүдэлтэй үйл ажиллагаа байлаа.

Abstract: In 1911 Mongolia restored its independence and Bogdo VIII Jibzundamba became a theocratic state khaan. Under his decree Ikh Shavi's Erdene shanzudba ministry was reorganized and was a new high ranks like the eighth main directions head and his deputy head. Theirs duty and authority less studied in the Mongolian historiography. I am spent some time at the State Central Archives and did some research on sources of the Erdene shanzudba ministry and Ministry of Internal Affairs duty and authority of the head office and its affiliations. This research results was touched in my paper.

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

Хавсралт. Бүгдийн дарга нарын үүрд дагаж явах дүрэм⁸³

Олноо өргөгдсөний тэргүүн он өвлийн дундсарын шинийн есөнд байгуулсан хишиг тараах зарлигийг дагаж Хүрээний найман зүгийн тус зүг дэх шавь нарыг захирах бүгдийн дарга нэмэн ор байгуулж тэдний шийдвээс зохих хэрэг зүйлийг их чуулганаар зөвлөлдөн ихэс танаа сонгон лавлаад тогтоосон баг саг дүрэм хэмжээ.

Нэгэн зүйл. Нийслэл хүрээний 8 зүгийн тус зүг дэхь шавийг захирах бүгдийн дарга 8-орыг нэгдэн засгийн хууль ёсоор явуулсаны тул аливаа засгийн хэрэг зүйлийг зөвлөн шийтгэх эрх өгч ихээхэн хэргийг уг байгуулсан зарлигыг дагаж манай Эрдэнэ шанзудба, Да лам танаа мэдүүлж тогтоолгохоос гадна аар саар зарга зайлхай, хулгай худлын хэргийг цөм түүгээр шийтгэн дуусгамай басхүү хошуушавь харилцан холбогдож харъяат зохих газар бичүүлэх зэрэг учир буй бөгөөс мөн түүгээр бичиг явуулж гүйцэтгэн шийтгэх хэрвээ хэрэг учир будилантай бөгөөд бүгдийн дарга нар өөрсдөө бичиглэж нэг тийш болгон чадах үгүй нь буй болгон даруй манай газар мэдүүлэн харъяат чуулган даргын зэрэг зохих газар явуулж гүйцэтгэн шийтгүүлэхэд бэлтгэвээс болмой.

Нэгэн зүйл. 8 зүгийн дэддарга нэгжгээд орыг нэгэнт туслагчийн хууль ёсоор явуулсаны тул зүй нь өөр өөрийн бүгдийн дарга нарт туслан хэрэг шийтгэвээс зохих бөгөөд аливаа мэдүүлэх, явуулах тушаах бичиг хэрэгт цөм нэгэн зэрэг холбоотой хэрэг бүхийг үзэж сонсовоос зохих тул тус тусын харъяат тамгийн жасааны ойр нутаглаж албаны хэргийг гүйцэтгэсүгэй.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн даргын тус захирах албаны газар жасаалан суулгах түшмэд манай Эрдэнэ шанзудбын газраас нэр зааж томилон гаргах 2 ор өөр өөрийн зүг нутгаас түүгээр томилон авч жасаалан суулгах түшмэл, бичээч нижгээд ор байгаад түшмэл зайсан, хөөлөгч, тайж, их, бага дарга, шүүлэнгэ зэрэг хүн нарын аль чадахыг сонгон нөхөн тогтоохтун.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн даргын тамгын газар зарлага хиа 4, зам нижгээд, ус, түлээ бэлтгэн хүн хошоодыг цөм түүгээр томилон авахаас гадна жич хулгай худлын зэрэг хэрэг халдсан хөнгөн ялын 1,2 дайтай болвоос зарлага хиа нарт тушааж харгалзан сахиултаас болох ба түүнээс бус хэрэгтний тоо олон болход хүрвээс өөр өөрийн харъяат отог багаас туслагч дарга, хуяг гаргаж чангалан сахиулагтун.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн дарга нарт тусгайлан хүртэх хишиг буй тул үл хэлэлцэн дэддарга нарыг түшмэл дадилтгаж тамгын жасаана суух зайсангуудын хамт түшмэл нэг хүнд өдөр тутам 60 шар цай, бичээчид өдөр тутам 45 шар цай, зарлага хиа, зам, ус, түлээ, хэрэгтний дарга, хуягуудад нэг адил өдөр тутам 35 шар цай бодож хүнс олгогтун

⁸³ МУУТА, ХА-74, Д-1, ХН-779, нуг 12.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн дарга нарт тамгын гэр засах үнэ мөнгө өөр өөрийн 50 лан олгохоос гадна жасаа албаны гэрүүдийг өөр тушааж бэлтгүүлсэн тул хянан шийтгэх сэлбэх зүйл буй аваас тухайбүр манай Эрдэнэ шанзудбын газар мэдүүлэн байцаан үзэж нөхөн засуулхад бэлтэгсүгэй.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн даргын газар албанд хэрэглэх цаас, тос, будаг балын шугам хүртэл үнийг төсөвлөн хэр зохисийг үзэж жил бүр 15 лан мөнгө тус тус тавин олгуулахаас гадна үүнээс дээш буй бүхий хэрэгсэх мөнгийг цөм жинхэнэ болгож санд барих албаны мөнгөнөөс суутган авч тайлан бодуулах.

Нэгэн зүйл. Санд барих аливаа албыг 8 зүгийн бүгдийн даргын газраас элч гаргаж хөөн шаардуулж тус тусын отог багын дарга шүүлэнг нарын газраас өөрсдийн харъяат санд тусгайлан гарын тэмдэг бичиг авч өөр өөрийн бүгдийн даргын газар тушаан өгч нийлүүлэн буцаахад бэлтгүүлсүгэй.

Нэгэн зүйл. Манай Монголчууд өөрөө дахин улс болон тогтнож бүхий цаг үүнд аливаа газарлуу улаа хэрэглэх явдалыг маш чандлан цаазлаж буй нь дээр саяхан Дотоод яамнаас өөрийн хэргийн тул өртөө улаа хэрэглэж үл болох учир байгуулсан зарлигыг дагаж 5 яамны сайд түшмэд бичээч өөрийнхөө хэргийн тул явах зорчих ба хүн зарах болвоос хувийн хүчин хэрэглэхээр тогтоож нэгэн адил мөрдөн дагаж явуулах тушаасан зүйл бэлхэн буй тул үүнээс хойш 8 зүгийн бүгдийн дарга, дэд дарга нараас дараалан тэдний тамгын жасаа суух түшмэд бичээч нар гэрт эргэх зэрэг өөрийн хэргийн тул зоргоор улаа хэрэглэж огт үл болмой. Жинхэнэ албаны хэргийн учир тус шавийн улаа нааш цааш ирэх буцах ба элч зарах болвоос эрхтэй хэргийн учир тодорхойлон тамга дарсан бичиг олгож явуулахаас гадна аливаа хэрэгтний уг хэрэг тохиолдсоны хүчин гаргаж залгуулахад хаяа уналга гаргаж чинээ үгүй аваас өөрийн албаны хэргийг залгуулахаас бус хөтлөх бүх улаа шүүс хэрэглэж огтхон ч үл болох явдалыг үүнд дагаж шийтгүүлсүгэй.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн дарга нар албаны хэргийн тул явах зорчих газар буй аваас дагалдах ард гурваад, дэд дарга нар дагалдах ард нижгээдээс хэтрүүлж үл болох ба өөрсдийн хэргийн тул олон отог багын ардыг дамай албадан зарцуулахыг үүрд цаазалсугай. Зорчин явах нь буй агаад албанаар байцаан гаргах буюу эсвээс хүндлэн хүн заалдваас саар үгүй нягтлан байцаан шийтгэмой.

Нэгэн зүйл. Урьд манай шавийн дотор харилцан холбогдсон өр ширийг шаардан гаргуулж өгсөн. Зарлага хиа нар шагнал хэмээн хоорондоор халдлан авах ба хөдөө хэрэг нийлэх түшмэл хэрэг тохиолдсон эдүүгээгээс хэрэглэл хэмээн мөнгө татан авч татсан гэмийг цаазлан зогсоож тушаасан зүйл буй аваас хаяа үл мэдэгчээр хуучин гэмийг халах үгүй зөрчин явахыг болзвоос үл болох тул үүнд хойш аливаа хэрэгтнийг зарлах ба жич өр ширийг шаардан гаргуулах зарлага хиа нарыг эрхбиш хүн төлөв итгэвээс болохыг сонгож томилон гарга. Хэрхэв ч урьд адил шалтаг хийж доорд шавь нарыг албадан дарлах хотлон мөлжих гэмийг үүрд

Их шавийн Бүгдийн даргын тамгын газрын тухай тодруулах нь
(1911-1915)

арилган цаазлаж дагаж явуулсугай.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн дарга нар албаны хэргээр уг захирсан отог нутгаас гарч явах зорчих хэрэг буй бөгөөс тамгыг өөр өөрийн дэд дарга нарт шилжүүлэн хамаарч хэзээ хэрхэн шилжүүлсэн ба хүлээн авсан өдрийг тухай бүр тодорхойлон мэдүүлж байцаан бэлтгүүлэхээс гадна мөнхүү бүгдийн дарга, дэд дарга нар хаяа бие өвдөх зэрэг албаны хэрэг шийтгэж чадах үгүй болгон хамт хэрэг шийтгэх түшмэлээс магадлан үзүүлж лавтай учир урьдаар бидний газар мэдүүлэн ирүүлэн хууль ёсоор чөлөө олгож өвчин засуулахад бэлтгүүлсүгэй.

Нэгэн зүйл. Манай газраас аливаа хэргийн учир улаа шүүс хэрэглэсэн, ес торгосон дүнг дөнгөлж, ташуур жанчиж шийтгэсэн эл хэргийг тодорхойлон байцааж жилийн эцэст зохих газар мэдүүлсэнээр ирсэн нь хэвээр журамлан шийтгэхийн тул олон харъяат бүгдийн дарга нарын газраас аливаа улаа шүүс хэрэглэсэн ба жич мал торгож шийтгэсэн дүн дөнгө, ташуур занчисан буй бүхий хэргийг тодорхой данс тэмдэглэж жил бүрийн 10 сарын дотор манай газар мэдүүлэн ирүүлээд хянан байцаахад бэлтгүүлэхээс гадна торгосон ялын малын дүнийг хадгалж албаны зүйлд зарцуулан хэрхэн зарцуулсан явдлыг жилийн эцэст тодорхойлон мэдүүлж тайлан бодуулах.

Нэгэн зүйл. Манай Эрдэнэ шанзудбын газраас олон хошуулугаа харилцаж шийтгэн дуусгах хэрэг зүйлийг зүг зовхис хувааж мөнхүү бүгдийн дарга нарын газраас ойр үзэж бичиглэх буюу хамт нийлж нэгэн тийш болгон шийтгэх явдалыг зохих газар явуулж нэгэнтэйгүүр уг хэргийн бичгийг ялган салгаж хуваан хүргүүлэх тул хэргийн тухайг үзэж хянан гүйцэтгэн шийтгүүлэхээс гадна хаяа баруун зүгийн бүгдийн даргад захирагдах отогын хүн зүүн зүгт нутаглаж суусан мэт бус зүгт захирагдсан хүн хаяа уг нутгийн харъяагаар холбогдсон хэрэг зүйлийг ойрыг үзэж мэдүүлэх эсвээс хулгай худлын хэрэгт нэг сүүлд холбогдох мэт хэрэг гарч ирвээс мөн эрх үгүй хүлээн авч байцаан шийтгэвээс зохимой. Гагцхүү хэргийн учир хүлээх үгүй ял шийтгэл гаргах зэрэг будилан буй аваас даруй үзэн учрыг сийрүүлэн зохих газар дамжуулан хүргүүлж жинхэнэ захирах газраас эрхлэн шийтгүүлэхэд бэлтгүүлсүгэй.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн даргын тус захирах албаны газар 15 хоногоор ээлжлэн уяа морийг уяа тутам 2-оор төсөвлөж 1 жилийн эцэс хаяа илүү сарыг тооцож бүгд 52 морь жич нижгээд сараар аргал, ус зөөх үхэр тэрэг 12-ыг тогтоосон тоо болгож уг зүгийн отгоос нийгэмчлэн хэрэглүүлвээс зохих боловч албан хэрэгт чинээ ядуурсан шавь нарыг нигүүсэн өршөөхийг үзүүлж энэ удаа Харчинаас татаж байгуулсан өрхөөс эрхлэн хураах морь малын дотроос зүг тутам 52 морь басхүү үхэр тэрэг 12-ийн оронд тэмээ 6 тус тус тавин олгуулж энэхүү дотроос жасаалан үзэж хэрэглүүлэх ба уг морь, тэмээг гаргаж бүгдийн дарга нарын газраас зохих газар тушааж амь батлан хадгалуулахаас гадна одоо

тавин олгуулах малыг аль газраас хүлээн авах явдалыг тусгай хуудас тушаалгаж гүйцэтгэн шийтгүүлсүгэй.

Нэгэн зүйл. 8 зүгийн бүгдийн дарга нарыг захирах жасаа албаны газар болвоос цагийг дагаж нүүж явах айл гэрийг дагалдуулахад чирэгдэх будилан үлэмж байлтай бөгөөд өөр өөрийн харъяалах газрууд төв хүрээ, сүм хурлын зэрэг суурин газар байгуулваас айл бүрт бат түшигтэй мэт тул Зүүн зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Сэнгэрийн Бор-Өндөрийн хурлын газар байгуулах, Зүүн өмнө зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Хөхөлийн суурин газар байгуулах, Өмнө зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Зогсоол хурлын газар байгуулах, Баруун өмнөзүгийн бүгдийн даргын тамгын жасааг Баянбулгийн газар байгуулах, Баруун зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Хөхнөтарамын хурлын газар байгуулах, Баруун хойд зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Тосны хурлын газар байгуулах, Хойд зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Уртцагаандоной хурлын газар байгуулах, Зүүн хойд зүгийн бүгдийн даргын тамгын жасааг Түмэний хурлын газар байгуулах.